



Understanding Children's Work
An Inter-Agency Research Cooperation Project



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТЭД ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТУУД ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар хот
2013

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх хамгийн сүүлийн үеийн тоон мэдээнээс¹ үзвэл “залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах” гэсэн Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтэд анхаарах шаардлагатай байна². Монголын залуучууд сургуулиас ажлын ертөнц рүү шилжихдээ олон бэрхшээлтэй тулгарч байна. Нийт залуучуудын 36 хувийг эзэлж буй хөдөөгийн залуусын боловсрол нэлээд доогуур, цалин бага, нийгмийн даатгалд хамрагдахгүй албан бус хэвшилд баталгаатай бус нөхцөлд ажиллаж байна. Хот, суурин газрын залуусын дунд ажилгүйдэл өндөр, удаан хугацаагаар ажилгүй байх нь түгээмэл байна. Боловсрол эзэмшсэн залууст ч ажил олоход хүндрэлтэй байна.

Залуучуудын ажиллах хүчний оролцоо

Монголын залуучуудын гуравны нэг нь эдийн засгийн идэвхтэй, 59 хувь нь суралцаж байна. Залуучуудын багахан хэсэг буюу 4 орчим хувь нь ажиллахын зэрэгцээ суралцаж байна. Залуучуудын ажиллах хүчин ба боловсролд хамрагдаж буй байдал байршлаас хамаарч нэлээд ялгаатай байна. Хөдөөгийн залуус хотын залуустай харьцуулахад эдийн засгийн идэвхтэй байх нь илүүтэй өндөр, харин суралцах нь харьцангуй бага байна. Ийнхүү хөдөөгийн залуус хүмүүн хөгжлийн капиталын түвшин доогуур байхдаа ажил эрхэлж эхэлж байгаа нь ирээдүйн зохистой хөдөлмөр эрхлэх боломжид нь таагүй нөлөөлөхөөр байгааг Хүснэгт 1-ээс харж болно.

Хүснэгт 1: 15-24 насны залуучуудын ажиллах хүч ба боловсрол дахь оролцоо, хот, хөдөө, хүйс, байршлаар

Хүн амын бүлэг		Ажиллах хүчинд багтаж буй (хүн амд эзлэх %)	Боловсролд хамрагдаж буй (хүн амд эзлэх %)	Идэвхгүй болон сургуулийн гадна байгаа (хүн амд эзлэх %)
Хот, хөдөө	Хот	25.1	63.7	13.7
	Хөдөө	45.8	49.8	12.7
Хүйс	Эрэгтэй	38.0	55.6	11.2
	Эмэгтэй	27.3	61.7	15.4
Бүс	Баруун	39.8	59.9	8.7
	Хангай	36.4	51.1	17.8
	Төв	42.7	52.7	11.9
	Зүүн	19.5	61.6	21.0
Байршил	Нийслэл	24.8	64.5	12.6
	Аймгийн төв	25.6	62.3	15.7
	Сумын төв	29.7	57.7	17.4
	Хөдөө	58.4	43.7	9.0
Нийт		32.7	58.6	13.3


Эх сурвалж: Монголын Ажиллах хүчний судалгааны 2011 оны тоон мэдээлэл ашиглан хийсэн ХАО төслийн тооцоо

¹ Энэ тайланд ҮСХ-ны 2011 оны АХС-ны тоо мэдээг ашиглав.

² Мянганы хөгжлийн зорилт 3

Ажиллах хүч ба боловсрол дахь оролцоог хүйсээр авч үзвэл жэндрийн ялгаа тод харагдаж байна. Хүснэгт 1-д харуулсанчлан, залуу эмэгтэйчүүдийн боловсролд хамрагдалтын түвшин эрэгтэйчүүдийнхээсээ өндөр байгаа хэдий ч сургуулиа төгссөний дараа ажил эрхэлж эхэлсэн эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага байна. Үүнийг 20-24 насны эмэгтэйчүүдийн дөрөвний нэг нь эдийн засгийн идэвхгүй, сургуульд ч суралцахгүй байгаагаас харж болно. Ийнхүү эмэгтэй хүн амын нэлээд хэсгийн бүтээлч нөөц, бололцоог ашиглаж чадахгүй байгаад бодлогын түвшинд анхаарал хандуулж, хөдөлмөрийн зах зээл дээр эмэгтэйчүүдийг тэгш боломжоор хангах хэрэгтэй байна.

Зураг 1: Залуучуудын ажиллах хүч, боловсрол дахь оролцооны хүйсийн ялгаатай байдал
Боловсролд хамрагдалт ба ажиллах хүчний оролцооны түвшин, нас, хүйсээр



Эх сурвалж: Монголын Ажиллах хүчний судалгааны 2011 оны тоон мэдээлэл ашиглан хийсэн ХАО төслийн тооцоо


Залуучуудын ажилгүйдэл

Монголын олон залуучууд ажил олж чадахгүй байна. Эдийн засгийн идэвхтэй залуучуудын бараг 11 хувь нь ажилгүйчүүд байна. Хэрэв ажил хийхэд бэлэн хэдий ч ажил идэвхтэй хайхгүй байгаа залуучууд буюу ажил хайхаас цөхөрсөн залуучуудыг оролцуулбал залуучуудын ажилгүйдлийн түвшин 16 хувь болж өсч байна.

Ажилгүй залуучуудын дийлэнх нь (83 хувь) анх удаа ажил хайж байгаа залуус байгаа нь ажил хөдөлмөрийн ертөнцөд залуус анх хөл тавихдаа тодорхой бэрхшээл, хүндрэлтэй тулгарч байгааг харуулж байна. Залуучуудын ажилгүйдлийн түвшин насанд хүрэгчдийнхээс хоёр дахин их байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий нөхцөл байдлаас үл хамаарсан өөр бусад хүндрэл бэрхшээл залууст тулгарч байгааг илтгэнэ.

Зураг 2: Залуучуудын ажилгүйдэл өндөр, ялангуяа Улаанбаатараас бусад суурин газарт илүү өндөр байна.

Хатуу тодорхойлолтоор тооцсон ажилгүйдлийн түвшин³ ба зөөлөн тодорхойлолтоор тооцсон ажилгүйдлийн түвшин,⁴ 15-24 насны бүлэг, хүйс, байршлаар



Эх сурвалж: Монголын Ажиллах хүчний судалгааны 2011 оны тоон мэдээлэл ашиглан хийсэн ХАО төслийн тооцоо

Залуучуудын ажилгүйдлийн үргэлжлэх хугацаа хэт урт удаан байна. Ажилгүй залуучуудын талаас илүү хувь нь (56 хувь) нэгээс дээш жилийн хугацаагаар ажилгүй, гуравны нэг нь гурваас дээш жилийн хугацаагаар ажилгүй байна. Ажилгүй байсан хугацаа нь ажилгүйдлийн улмаас учрах хор хохирлыг тооцоход чухал үзүүлэлт болдог. Богино хугацааны ажилгүйдэл нь залуучууд өөрийн “хүссэн” ажлаа олохын тулд ажил идэвхтэй хайсныг илэрхийлдэг. Харин залуу насандаа урт удаан хугацаагаар ажилгүй байх аваас тухайн хүний бүтээлч нөөц бололцоонд эргэшгүй хохирол учруулж, ирээдүйн ажил, цалин хөлсний төлөвт нөлөөлдөг.

Хотын залуус ажилгүйдэлд илүү их өртөж байна. Хотын залуусын ажилгүйдлийн түвшин хөдөөгийн залуучуудынхтай харьцуулахад хоёр дахин илүү байгаа нь хот, хөдөөгийн хөдөлмөрийн зах зээлийн шинж байдлын ялгааг, ялангуяа хөдөө аж ахуйн салбар хөдөөгийн ажилчдыг багтаан шингээхэд чухал үүрэг гүйцэтгэж байгааг харуулж байна. Залуучуудын ажилгүйдэл ялангуяа аймгийн төв (19 хувь), сумын төвүүдэд (17 хувь) илүү өндөр байна (Зураг 2). Хотын залуус ажил олоход хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаа бол хөдөөгийн залуусын хөдөлмөрийн зах зээл дээрх эмзэг байдал нь тэдний ажил эрхлэлтийн чанартай холбоотой байна.

Залуучуудын ажил эрхлэлтийн чанар

Монголын залуучуудын ажил эрхлэлтийн чанарын асуудал ажил хайж олох асуудлаас ч дутахааргүй анхаарал татаж байна. Ажил эрхэлж буй залуучуудын олонхи нь бүтээмж

3 “Хатуу” тодорхойлолтоор тооцсон ажилгүйдлийн түвшин гэж эдийн засгийн идэвхтэй байгаа хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хэвийг хэлнэ.


4 “Зөөлөн” тодорхойлолтоор тооцсон ажилгүйдлийн түвшин гэж ажилгүйчүүд болон ажил хийхэд бэлэн, ажиллаагүй байгаа хүмүүсийн нийлбэрийг эдийн засгийн идэвхтэй өргөтгөсөн хүн амд эзлэх хувийг хэлнэ. Эдийн засгийн идэвхтэй өргөтгөсөн хүн ам гэж ажил хийхэд бэлэн, ажиллаагүй байгаа болон эдийн засгийн идэвхтэй хүн амын нийлбэр юм.

муутай, байнгын цалинтай бус, албан бус хэвшилд ажиллаж байна. Нийт ажил эрхэлж буй залуучуудын дөнгөж 42 хувь нь цалинтай ажил эрхэлж байна (Зураг 3).

Гэвч үүнээс бага хувь буюу ажил эрхэлж буй залуучуудын 35 хувь нь албан хэвшилд (хөдөлмөрийн зах зээлийн статистикийн талаарх олон улсын хэм хэмжээнд тусгагдсан тодорхойлолтын дагуу тогтоогдсон) ажиллаж байна (Зураг 4). Албан хэвшилд ажиллагчдын эзлэх хувь бол ажил эрхлэлтийн чанарыг тодорхойлох гол үзүүлэлт юм. Албан хэвшилд ажиллагчдын ажлын байр илүү тогтвортой, хуулийн хамгаалалттай, цалин орлого илүүтэй, тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал зэрэг нийгмийн баталгаагаар хангагдсан байдаг. Хууль эрх зүй, эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгааг бий болгох замаар залуу ажиллагчдыг албан бус хэвшлээс албан хэвшилд шилжүүлэх нь Монгол улсын хувьд баримтлах бодлогын гол зорилтуудын нэг болох учиртай.

Зураг 3: Залуучуудын талаас бага хувь нь цалинтай ажил эрхэлж байна.

Ажил эрхэлж буй залуусын эзлэх хувь, ажил эрхлэлтийн статус ба эдийн засгийн салбараар




Эх сурвалж: Монголын Ажиллах хүчний судалгааны 2011 оны тоон мэдээлэл ашиглан хийсэн ХАО төслийн тооцоо

Хөдөөгийн залуучуудын ажил эрхлэлтийн чанар хамгийн муу байна. Хөдөөд ажиллаж буй залуучуудын дөнгөж 6 хувь нь албан хэвшилд ажиллаж, үлдсэн дийлэнх нь мал аж ахуйд (68 хувь) болон өрхийнхөө аж ахуйд цалингүй ажиллаж (20 хувь) байгаа нь ядуурлаас гарах, ажил мэргэжлээрээ өсөн дэвжих боломжоор хязгаарлагдмал байна. Орон нутгийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, залуучуудын бизнес эрхлэх ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх болон бусад арга замаар хөдөлмөр эрхлэлтийн бусад боломжийг нэмэгдүүлэх нь хөдөөгийн залуучуудын талаар баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл болох ёстой. Нийслэл Улаанбаатарт ажиллаж буй залуусын дөрөвний гурав нь цалинтай ажил эрхэлж, гуравны хоёр нь албан хэвшилд ажиллаж байгаагаас үзэхэд залуучуудын ажил эрхлэлтийн чанар нийслэлд хамгийн өндөр байна.

Зураг 4: Ажил эрхэлж буй залуучуудын, ялангуяа хөдөө ажил эрхэлж буй залуучуудын ихэнх нь албан бус хэвшилд ажиллаж байна.

Албан ба албан бус хэвшилд⁵ ажиллаж буй залуучуудын нийт ажил эрхэлж буй залууст эзлэх хувь, 15-24 насны бүлэг, хүйс, байршлаар



Эх сурвалж: Монголын Ажиллах хүчний судалгааны 2011 оны тоон мэдээлэл ашиглан хийсэн ХАО төслийн тооцоо

Хүмүүн капитал ба залуучуудын ажил эрхлэлтийн үр дүн

Монголын сургуульд суралцаагүй байгаа залуусын гуравны хоёр нь наанадаж дунд боловсролтой байна. Энэ бол дунд ба дээд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн амжилтанд хүрснийг харуулж байна. Гэсэн хэдий ч сургуульд одоо суралцаагүй байгаа залуучуудын дунд эзлэх хүмүүн капиталын хөгжлийн доогуур түвшинд байгаа, боловсрол эзэмших “хоёрдахь боломж”-оор хангагдах хэрэгцээтэй залуучуудын эзлэх хувь тийм ч бага биш байна. Ялангуяа хөдөөгийн залуусын хувьд энэ асуудал бүр ч их хамаатай. Сургуульд суралцаагүй байгаа хөдөөгийн залуусын 15 хувь нь ямар ч боловсрол эзэмшээгүй, 36 хувь нь бага боловсролтой болон боловсролгүй байна. Ихэнх тохиолдолд эдгээр залуус албан бус хэвшилд ажиллаж, цаашдаа ажил мэргэжлээрээ ахиж дэвжих, нийгэмдээ хөгжих боломжоор хязгаарлагдмал байна. Нөгөөтэйгүүр, дээд боловсролын чанар нь хүртээмж нэмэгдсэн шигээ дээшилж чадаагүйг бусад судалгаанд тэмдэглэжээ. Боловсрол, сургалтын тогтолцоо залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд хэр зохистой бэлтгэж байгаа асуудал ийнхүү анхаарал татсаар байна⁶.

Боловсролтой залуучуудын ажилгүйдэлд өртөх эрсдэл өндөр байна. Мэргэжлийн/техникийн боловсролтой (19 хувь) ба дээд боловсролтой залуучуудын (16 хувь) ажилгүйдлийн түвшин арай доогуур боловсролтой залуучуудтай харьцуулахад хамаагүй өндөр байна (Зураг 6). Энэ бол боловсрол багатай залуус хөдөлмөрийн зах зээлд бусдаасаа арай эрт хөл тавьж, хөдөлмөрийн зах зээлд оролцсон хугацаа нь урт байхын хэрээр ажил олох боломж нь нэмэгдсэн байдагтай холбоотой. Илүү өндөр боловсролтой залуусын тухайд бол тэдний ажилгүй байгаа хугацаа ихэнх тохиолдолд хэт урт байна.


5 Албан ба албан бус эдийн засаг дахь хөдөлмөр эрхлэлтийг ялгахдаа хөдөлмөрийн статистикийн талаарх олон улсын хэм хэмжээг ашигласан

6 Жишээ нь, ЮНЕСКО (2009) Монголын боловсролын тогтолцоонд хийсэн шинжилгээ; ЮНЕСКО Бангкок; Дэлхийн Банк (2007) Монгол улсын эдийн засгийн шинэ нөхцөл байдалд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх нь, Дэлхийн Банкны Ази, Номхон далайн Бүсийн Хүний Хөгжлийн Хэлтсийн тайлан, Дугаар 40118.

Мэргэжлийн/техникийн боловсролтой залуусын 60 хувь нь нэгээс дээш жил ажил хайсаар байгаа ажээ.

Зураг 5: Хөдөөгийн залуусын хүмүүн капиталын хөгжлийн түвшин хамгийн доогуур байна.


Боловсролын түвшин, 15-24 насны суралцаагүй байгаа залуучууд, хүйс, байршлаар



Эх сурвалж: Монголын Ажиллах хүчний судалгааны 2011 оны тоон мэдээлэл ашиглан хийсэн ХАО төслийн тооцоо

Зураг 6: Боловсрол өндөртэй залуучуудын ажилгүйдэлд өртөх эрсдэл илүү байна.

Хатуу тодорхойлолтоор тооцсон ажилгүйдлийн түвшин, 15-24 насны суралцаагүй байгаа залуучууд, боловсролын түвшингээр




Эх сурвалж: Монголын Ажиллах хүчний судалгааны 2011 оны тоон мэдээлэл ашиглан хийсэн ХАО төслийн тооцоо

Боловсролтой залуучуудын дунд ажилгүйдэл өндөр байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээр ур чадварын эрэлт, нийлүүлэлт нийцэхгүй, залуус ажил эрж хайхад нь үзүүлэх дэмжлэг тусалцаа сул байгааг илэрхийлнэ. Ажилгүйдэл ба боловсролын түвшин хоорондох хүчтэй эерэг хамаарал нь боловсролын тогтолцоогоор олгож байгаа ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгааг илтгэхийн зэрэгцээ ажил хайж буй ур чадвартай ажиллагчид ба ажил олгогчдыг холбох механизмыг

боловсронгүй болгох шаардлагатайг харуулж байна. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байгаа ур чадварыг Монголын залуучууд нэлээд муу гүйцэтгэдэг⁷, ажил олгогчид шинээр ажилд авсан ажилчдын ур чадварыг голж байгааг⁸ зарим судалгаагаар дүгнэжээ. Залуус голдуу гэр бүлийн гишүүд, найз нөхдөөр болон бусад албан бус сүлжээгээр дамжуулан ажил эрж олдгийг мөн судалгаануудад тэмдэглэсэн байна⁹.

Зураг 7: Илүү өндөр боловсролтой залуус албан хэвшилд, цалинтай ажил эрхэлж байна.

*Эзэмшсэн боловсролын түвшин ба ажил эрхлэлтийн хэвшил,
15-24 насны суралцаагүй байгаа залуус*



Эх сурвалж: Монголын Ажиллах хүчний судалгааны 2011 оны тоон мэдээлэл ашиглан хийсэн ХАО төслийн тооцоо

Ажил эрхлэлтийн чанар боловсролын түвшинтэй уялдаатай байна. Үүнийг албан ба албан бус хэвшилд ажиллаж буй залуусын эзлэх хувийг боловсролын түвшингээр нь авч үзсэн Зураг 7-оос харж болно. Албан хэвшил дэх ажил эрхлэлт боловсролын түвшин нэмэгдэх тусам дээшилж байгаа ба ажил эрхэлж буй дээд боловсролтой таван залуугийн дөрөв нь албан хэвшилд ажил эрхэлж байна. Мэргэжлийн/техникийн боловсрол эзэмших нь албан хэвшилд ажил эрхлэх баталгаа болж чадахгүй байгааг энд тэмдэглэх нь зүйтэй. Мэргэжлийн/техникийн боловсролтой залуусын 43 хувь нь албан бус хэвшилд ажиллаж байна. Үүнээс гадна эдгээр залуусын дунд ажилгүйдэл мөн өндөр байгаа нь эргээд л мэргэжлийн боловсролын сургалтын тогтолцоо хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгаа асуудлыг хөндсөөр байна.

7 Дэлхийн Банк (2007)

8 ОУХБ (2008) Монголын залуусын сургуулиас ажилд шилжих шилжилт, Хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан, Дугаар 14

9 ОУХБ (2008)

ОУХБ-ын Монгол Улс, БНХАУ-ыг хариуцсан товчоо

ILO office for China and Mongolia

Tayuan Diplomatic Office Building

Beijing 100600, P.R.China

Tel: 86 10 6532 5091/5092

Fax: 86 10 6532 0073

НҮБ-ын байр, Өрөө 209

Нэгдсэн үндэстний гудамж

Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар 14201, Монгол Улс

Утас: 976 11320624

Факс: 976 11320625

<http://www.ilo.org>

UCW at the ILO office for Italy and San Marino

Via Panisperna 28

00184 Rome, Italy

Tel. +39 06 4341 2008

Fax: +39 06 6792 197

UCW at the Centre for International Studies on Economic Growth (CEIS)

V. Columbia 2

00133 Rome, Italy

Tel. +39 06 7259 5618

Fax: +39 06 2020 687

Website: www.ucw-project.org

E-mail: info@ucw-project.org